



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ХАДГАЛАМЖ БАЙРШУУЛАХ ЖУРМЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

Сангийн яамны Төрийн сангийн газрын мөнгөн
хөрөнгийн зохицуулалт

Агуулга

Тайланг бэлтгэсэн:	Ерөнхий зүйл.....	2
<i>УАГ-ын Нэгдүгээр газрын захирал Д.Ганбилэг</i>	1. Аудит хийсэн үндэслэл	
<i>Аудитын менежер Ж.Батсайхан</i>	2. Аудитын зорилт, хамарсан хүрээ	
<i>Ахлах аудитор Ц.Гэрэл</i>	3. Аудитын арга зүй	
<i>Шинжээч Ш.Энхтайван</i>	4. Төрийн сангийн талаархи товч танилцуулга	
<i>Хянасан аудитын менежер Ж.Батсайхан</i>	Бүлэг 1: Мөнгөн хөрөнгийн зохицуулалт хийх боломж нэмэгдэж байна.....	5
	1.1 Төсвийн орлогын төлөвлөгөө биелжээ	
	1.2 Мөнгөн хөрөнгийн зохицуулалтад тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна	
	Бүлэг 2: Өглөгийн дүнг бууруулжээ.....	9
2007 оны 7 дугаар сар	Дүгнэлт.....	13
<i>Уг тайланг УАГ-ын Веб сайт-аас үзнэ үү.</i>	Зөвлөмж.....	13
www.mnao.pmis.gov.mn	Товчилсон үгс:	
<i>Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261885 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.</i>	УАГ - Үндэсний аудитын газар	
	УИХ - Улсын Их Хурал	
	ТС - Төрийн сан	
	ТСНД - Төрийн сангийн нэгдсэн данс	
	АОУС - Аудитын олон улсын стандарт	
	ЗГСУМС- Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн систем	
	ЗГ - Засгийн газар	
<i>Үндэсний аудитын газар Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-6, Улаанбаатар-46 Монгол Улс</i>	ЗГСНТ - Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан	

Ерөнхий зүйл

1. Аудит хийсэн үндэслэл

Аудитыг Засгийн газрын 2006 оны санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн аудитаар тогтоосон эрсдэлийг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

2. Аудитын зорилт, хамарсан хүрээ

Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн аудитаар тогтоосон зарим эрсдэлтэй асуудалд аудит хийж, үр нөлөөг сайжруулах санал зөвлөмж боловсруулан, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтыг хангахын тулд дараахь чиглэлээр аудит хийлээ.

- Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн зохицуулалт, үр ашиг
- Сангийн яамны Төрийн сангийн газарт байршиж байгаа төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2006 оны харилцах дансны үлдэгдэл болон Монголбанк дахь төгрөгийн харилцах дансны үлдэгдлийн зөрүү

Аудитаар Сангийн яамны Төрийн сангийн газрын 2004-2006 оны санхүүгийн болон бусад холбогдох материалыг шалгалаа.

3. Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ АОУС, Төрийн хяналт шалгалтын стандарт, эрсдэлийн аудитын арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад эрсдэлийн аудитын үндсэн элементүүд болох үнэн зөв байдал, зүй зохис болон санхүүгийн хяналттай холбоотой асуудлыг авч үзлээ.

Аудитыг Үндэсний аудитын газрын Нэгдүгээр газрын захирал Д.Ганбилэг, аудитын менежер Ж.Батсайхан нар удирдаж, ахлах аудитор Ц.Гэрэл, шинжээч Ш.Энхтайван нар 2007 оны 6 дугаар сарын 21-нээс 7 дугаар сарын 2-ны хооронд хийж гүйцэтгэв.


4. Төрийн сангийн талаархи товч танилцуулга

Сангийн яамны Төрийн сангийн газар Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн дагуу төсвийн хэрэгжилтийг хангаж, төлбөр тооцоо гүйцэтгэх, тайлагнах, төсвийн алдагдал, төсөл хөтөлбөрийг хамгийн бага зардлаар, төлбөрийн чадвартай уялдуулан санхүүжүүлэх чиг үүрэгтэй.

Төрийн сангийн газар 1993 онд байгуулагдаж Засгийн газрын 2002 оны 101 дүгээр тогтоолоор Төрийн сангийн нэгдсэн тогтолцоонд шилжин, арилжааны банкуудад байршиж байсан улсын төсвийн байгууллагуудын харилцах дансны үлдэгдлийг Төрийн сангийн нэгдсэн дансны тогтолцоонд төвлөрүүлэн байршуулж банкны төлбөр тооцооны үйлчилгээг үзүүлж эхэлжээ.

Төрийн сангийн үйлчилгээг боловсронгуй болгох, санхүүгийн нэгдсэн сүлжээ бий болгох, төлбөр тооцоог цаг тухайд нь хүргэх зорилгоор 2005 оноос Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн систем /GFMIS/-ийг нэвтрүүлжээ.

Төрийн сангийн газрын бүтцийг харуулбал:



Санхүүжилт тайлан бүртгэлийн хэлтэс нь Засгийн газрын мөнгөн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх, төсвийн санхүүжилтийг хугацаанд нь санхүүжүүлэх, улсын болон нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг цаг хугацаанд тайлагнах үүрэгтэй.

Төлбөр тооцооны хэлтэс нь төсвийн байгууллагуудын анхан шатны баримтыг үндэслэн батлагдсан төсвийн дагуу төлбөр тооцоог гүйцэтгэж, цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэл хөтөлж, банк болон салбар хоорондын төлбөр тооцоог гүйцэтгэх чиг үүрэгтэй.

Өрийн удирдлагын хэлтэс нь төсвийн алдагдал болон төсөл, хөтөлбөрийг хамгийн бага зардлаар, төлбөрийн чадвартай уялдуулан санхүүжүүлэх, Засгийн газрын өрийн удирдлагыг хэрэгжүүлэх үүрэг гүйцэтгэдэг.

Бүлэг 1: Мөнгөн хөрөнгийн зохицуулалт хийх боломж нэмэгдэж байна

1.1 Төсвийн орлогын төлөвлөгөө биелжээ

Монгол Улсын 2006 оны төсвийн тухай хуулиар батлагдсан ТС-ийн дотоод орлогын 100.0 сая төгрөгийн төлөвлөгөө 5.3 тэрбум төгрөгөөр давж биелжээ.

ТС-ийн 2004-2006 оны мөнгөн хөрөнгийн ашиглалтаас олсон орлого, зарлагыг хүснэгтээр харуулав.

*/Хүснэгт1/
төгрөгөөр/*

/мянган

№	Орлого, зарлагын нэр төрөл	2004	2005	2006
1	Хүүгийн орлого	1,099,013.6	1,120,616.2	5,103,768.5
2	Хүүний зардал	2,612,436.6	92,978.1	996,093.7
3	Хүүний цэвэр ашиг /1-2/	-1,513,423.0	1,027,638.1	4,107,674.8
4	Ханшийн зөрүүний орлого	5,342,511.9	5,250,153.3	5,052,287.9
5	Ханшийн зөрүүний алдагдал	3,847,672.1	6,038,856.9	3,766,145.9
6	Ханшийн зөрүүний цэвэр ашиг /4-5/	1,494,839.8	-788,703.6	1,286,142.0
	Нийт ашиг /3+6/	-18,583.2	238,934.5	5,393,816.8

Тус газар 2004 онд мөнгөн хөрөнгийн ашиглалтаас 1.5 тэрбум төгрөгийн алдагдал хүлээж, валютын ханшийн өөрчлөлтөөс 1.49 тэрбум төгрөгийн ашиг олж нийт 18.6 сая төгрөгийн алдагдал хүлээжээ. 2005 оноос банкуудад байршуулж орлого олдог актив/байршуулсан хадгаламж/-ын хэмжээ өссөнөөр хүүгийн орлогын зөрүү 1.0 тэрбум болж өссөн хэдий ч ханшийн зөрүүнээс 0.8 тэрбум төгрөгийн алдагдал хүлээж, нийт дүнгээр 238.9 сая төгрөгийн ашигтай ажиллажээ. Харин 2006 онд төсвийн орлого өссөний дүнд мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдсэн байна. Үүний дүнд арилжааны банкуудад байршуулсан хадгаламжийн дүн нэмэгдсэн бөгөөд гадаад валютын нөөцөө банкинд байршуулснаар мөнгөн хөрөнгийн ашиглалтаас 5.4 тэрбум төгрөгийн ашиг олсон байна.

1.2 Мөнгөн хөрөнгийн зохицуулалт

Монгол банк болон арилжааны банкуудад байршуулсан хадгаламж, харилцахын үлдэгдлийг 2006 оны жилийн эцсийн байдлаар дараахь хүснэгтэд харуулав. ТС-ийн мөнгөн хөрөнгийн нийт үлдэгдэл 2006 оны эцэст 314,9 тэрбум төгрөг байгаагийн 78,9 тэрбум төгрөг буюу 25,0 хувь нь Төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байна.

/Хүснэгт2/**/сая төгрөгөөр/**

Сарууд	Төгрөгийн харилцах данс	Ам.долларын харилцах данс	Еврогийн харилцах данс	Бусад валют	МУ-г хөгжүүлэх сан	Нийт үлдэгдэл
2006.01.01	48,113.3	13,874.5	3,569.6	0.9	0.00	65,558.3
2006.02.01	51,396.3	13,758.5	2,469.9	0.9	0.00	67,625.6
2006.03.01	83,605.5	12,561.3	1,554.5	1.3	0.00	97,722.6
2006.04.01	87,663.2	3,664.2	894.8	1.2	0.00	92,223.4
2006.05.01	81,667.4	12,161.1	787.2	1.3	0.00	94,617.0
2006.06.01	91,154.2	21,427.4	598.0	1.5	0.00	113,181.1
2006.07.01	96,412.5	38,044.8	537.5	1.5	0.00	134,996.3
2006.08.01	99,848.8	4,665.3	2.6	1.5	0.00	104,518.2
2006.09.01	109,934.1	142,825.9	301.3	2.1	0.00	
2006.10.01	111,911.0	59,152.9	215.1	2.1	0.00	171,281.1
2006.11.01	35,271.9	125,943.1	121.9	2.1	0.00	161,339.0
2006.12.01	121,817.9	79,978.3	1.1	3.1	115,000.00	316,800.4
2006.12.31	68,128.23	67,390.8	1,965.2	3.1	177,500.00	314,987.3

Арилжааны банкуудад 2006 онд байршуулсан хадгаламж, хүүгийн түвшинг хүснэгтээр харуулав:

/Хүснэгт3/**/сая төгрөгөөр/**

№	Банкны нэр	Эхний үлдэгдэл	2006 онд байршуулсан хадгаламж	2006 онд төлөгд-сөн дүн	Төлөгд сөн хүү	Хүү /дундаж хувь/	Хадгаламжийн үлдэгдэл
1	Хадгаламжийн банк	6,996.5	17,494.50	24,490.9	89.7	4.16	0.00
2	Улаанбаатар хотын банк	10,000.0	31,000.00	29,000.0	366.0	3.80	12,000.00
3	Зоос банк	15,000.0	9,500.00	5,000.0	546.0	3.94	19,500.00
4	Голомт банк	10,000.0	5,000.00	0.0	501.3	4.50	15,000.00
5	Кредит банк	0.0	13,400.00	13,400.0	64.0	3.40	0.00
6	Худалдаа хөгжлийн банк	0.0	25,000.00	25,000.0	60.4	3.23	0.00
7	Хаан банк	0.0	36,400.00	36,400.0	48.3	3.51	0.00
8	Чингис хаан банк	0.0	10,000.00	10,000.0	162.6	4.00	0.00
9	Капитрон банк	0.0	13,100.00	6,000.0	191.7	4.17	7,100.00
10	Хас банк	0.0	1,000.00	1,000.0	1.2	3.00	0.00
11	Анод банк	7,000.0	0.0	7,000.0	19.4	4.00	0.00
12	Монгол шуудан банк	5,000.0	0.0	5000.0	6.1	4.00	0.00
13	Нийт	53,996.5	161,894.5	162,290.9	2,353.0	3.77	53,600.00

Тайлант хугацаанд өссөн дүнгээр ТСНД-аас 161.9 тэрбум төгрөгийн хадгаламжийг арилжааны банкуудад байршуулж, 162.3 тэрбум төгрөгийг буцаан төлүүлж, 2006 оны эцэст Арилжааны банкуудад 53.6 тэрбум төгрөгийн хадгаламжийн үлдэгдэлтэй гарчээ. Хадгаламжийг 1-ээс 94 хоногийн хугацаатай, банкуудын санхүүгийн чадвар, хадгаламжийн хугацаанаас хамаарч 3-аас 4.5 хувийн хүүтэйгээр байршуулсан байна. Төгрөгийн хадгаламж байршуулснаас 2.4 тэрбум төгрөгийн хүүгийн орлогыг бүрдүүлэн улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Түүнчлэн өссөн дүнгээр 445.0 сая ам.долларын хадгаламжийг Монголбанк болон ХААН банкинд байршуулж 2.4 сая ам.долларын хүүгийн орлого олжээ.

ТС-ийн газар Монголбанк болон арилжааны банкуудад зээл олгох, хадгаламж байршуулахдаа Санхүү, эдийн засгийн сайдын 2004 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 50 дугаар тушаалаар баталсан “Арилжааны банкуудад овернайт зээл олгох журам”, “Төрийн сангийн хадгаламж байршуулах, хадгаламжийн сертификат худалдан авах түр журам”-ыг мөрдлөг болгон ажилладаг. Арилжааны банкуудад олгосон зээл, байршуулсан хадгаламжийг шалгах явцад дээрх журмуудыг зөрчсөн болон журмуудад нэмж тусгах дараахь асуудлууд илэрлээ:

- Журмын 2.1-д “Сүүлийн 6 сард зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн 90-ээс дээш хувийг хангасан байх” шаардлагыг тусгасан байна. ТС-ийн газар нь Монголбанкнаас зөвхөн телефон утсаар лавлагаа авдаг ба үүнийг бичгээр авч баталгаажуулах шаардлагатай байна.
- Дээрх журмуудад зээлийн болон хадгаламжийн хугацааг сунгах, түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар тусгаагүй байна. Энэ нь тодорхой эрсдэлийг бий болгох ба нөгөө талаас хариуцлагыг сулруулж байна. Жишээлбэл: 2006 онд Кредит банкинд 2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр олгосон 91 хоногийн хугацаатай 3 тэрбум төгрөгийн хадгаламжийн хугацааг 4 удаа сунгасан ба 2006 оны 11 дүгээр сарын 23-нд төлөгдсөн байна.
- “Арилжааны банкуудад овернайт зээл олгох журам”-ын 5.1-д “Төрийн сангийн газрын овернайт зээл хариуцсан мэргэжилтэн нь баталгаажсан саналын хуудсыг үндэслэн төлбөрийн баримтыг бэлтгэж Төлбөр тооцооны хэсэгт өгнө”, “Төрийн сангийн хадгаламж байршуулах, хадгаламжийн сертификатыг худалдан авах тухай түр журам”-ын 4.5-д “Төрийн сангийн газрын мэргэжилтэн нь хадгаламжийн хэмжээ, хүүгийн хувь хэмжээний саналыг бэлтгэж Төрийн сангийн газрын даргад танилцуулж баталгаажуулсан болон татгалзсан саналын хуудсыг санал ирүүлсэн арилжааны банкуудад хүргүүлнэ” гэж заасан байна. Энэ нь ямар албан тушаалтан шийдвэр гаргах, түүнийг хэрхэн баталгаажуулах асуудлуудыг тодорхойлоогүй байна.
- “Арилжааны банкуудад овернайт зээл олгох журам”-ын 6.2-т “Овернайт зээлийн үйл ажиллагаанд Төрийн сангийн газрын дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн хяналт тавьж ажиллана”, “Төрийн сангийн хадгаламж байршуулах, хадгаламжийн сертификатыг худалдан авах тухай түр журам”-ын 6.2-т “Төрийн

сангийн хадгаламж байршуулах үйл ажиллагаанд Төрийн сангийн газрын Дотоод хяналтын хэсэг хяналт тавьж ажиллана” гэж заажээ. Гэвч 2007 оны байдлаар тус газрын бүтцэд дотоод хяналт хариуцсан ажилтан, алба алга байна.

Бүлэг 2 Өглөгийн дүнг бууруулжээ

Монгол Улсын Засгийн газрын 2006 оны санхүүгийн нэгдсэн тайланд богино хугацаат өр төлбөрийг 236,2 тэрбум төгрөгөөр тайлагнажээ. Үүнийг хүснэгтээр харуулвал:

<i>/Хүснэгт4/</i>		<i>/сая төгрөгөөр/</i>			
№		ОНТЕЗ	УТЕЗ	ТӨҮГ	Дүн
1	Богино хугацаат үнэт цаас		38,157.5		38,157.5
2	Богино хугацаат зээлийн өглөг	2,510.49	31.71		2,542.2
3	Өглөг	410.9	82,830.73	88,618.3	171,859.93
4	Урдчилж орсон орлого	45.0	14,968.34	8,671.36	23,684.7
5	Нийт дүн	2,966.39	135,988.28	97,289.66	236,244.33

Богино хугацаат өр төлбөрийн 171,859.93 сая төгрөгийн өглөгийг бүтцийн хувьд задлан харуулав.

<i>/Хүснэгт5/</i>		<i>/сая төгрөгөөр/</i>
№	Үзүүлэлтүүд	Санхүүгийн тайлангаар
1	Ажиллагсадтай холбоотой тооцоо	11,692.23
2	Бараа үйлчилгээний зардлын тооцоо	27,210.85
3	Татаас, санхүүжилт, шилжүүлгийн тооцоо	2,605.3
4	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон тооцоо	1,127.53
5	Зээлийн хүүгийн тооцоо	38,961.05
6	Бусад өглөг	90,262.97
	Дүн	171,859.93

Засгийн газрын 2006 оны Санхүүгийн нэгдсэн тайлангийн богино хугацаат өр төлбөрийн өглөг хэсэгт тусгагдсан бусад өглөгийн 90,262.97 сая төгрөгийн дүнд ТС-ийн газрын 19,094.85 сая төгрөгийн өглөг бүртгэгдсэн байна. Үүнийг бүтцээр харуулав.

<i>/Хүснэгт6/</i>		<i>/сая төгрөгөөр/</i>
№	Үзүүлэлт	Дүн
1	Монгол Улсыг Хөгжүүлэх сангийн зөрүү үлдэгдэл	20.6
2	Эрсдэлийн сангийн зарцуулагдаагүй үлдэгдэл	7,650.0
3	АНУ-ын тусламжийн хөрөнгийн үлдэгдэл	869.5
4	Төсвийн байгууллагын үлдэгдлээс авч ашигласан хөрөнгө	10,811.0
5	Төсөвт байгууллагуудын гадаад төлбөрийн өглөг	426.5
6	Төсөвт байгууллагуудаас авах авлага	(683.5)
	Дүн	19,094.1

Засгийн газрын 2006 оны Санхүүгийн нэгдсэн тайланд тусгасан Төсвийн байгууллагын харилцах дансны үлдэгдлээс авч ашигласан хөрөнгийн өглөг 10,811.0 тэрбум төгрөг хэрхэн бүртгэгдсэнийг 2004, 2005, 2006 оны тайлант хугацааг хамруулан авч үзвэл дараахь байдалтай байна.

ТС нь улсын төсвийн байгууллагуудын харилцах дансны үлдэгдлийг Төрийн сангийн нэгдсэн дансны тогтолцоонд төвлөрүүлэн байршуулж банкны төлбөр тооцооны үйлчилгээг хэрэгжүүлэхдээ банкны бүртгэлийн BUMIS программыг хэрэглэж байгаад 2005 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс Сангийн сайдын 2004 оны 276 тоот тушаалаар ЗГСУМС-ийн Фрибаланс программд шилжжээ. Энэ программ нь төсвийн ерөнхийлөн захирагч нарын мөнгөн хөрөнгө, түүний зарцуулалтад хяналт тавих зориулалтаар ашиглагдаж байна.

ТС-ийн 2004 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн BUMIS /банкны бүртгэлийн/ программаар гаргасан тухайн оны жилийн эцсийн балансыг хүснэгтээр харуулав:

<i>/Хүснэгт 7/</i>			<i>/сая төгрөгөөр/</i>	
№	Актив	Дүн	Пассив	Дүн
1	Монголбанкин дахь төрийн сангийн харилцах	41,658.3	Дээд сургуулиудын харилцахын үлдэгдэл	648.1
	Хадгаламжийн банк дахь касс	200.0	Төсвийн ерөнхийлөн захирагч нарын харилцах, НД, орон нутгийн төсвийн захирагчдын харилцахын үлдэгдэл	89,297.4
2	Улсын нэгдсэн төсвөөс авах авлага	48,087.3		
	Нийт актив	89,945.7	Нийт пассив	89,945.7

Энэхүү балансаар Төсвийн ерөнхийлөн захирагч нарын харилцах дансны үлдэгдэл Төв ТС-ийн балансын пассив талд өглөгөөр тусгагдсан ба Монголбанк дахь харилцах дансны үлдэгдлээс 48,087.3 сая төгрөгөөр илүү байна. Энэхүү 48,087.3 сая төгрөг нь улсын нэгдсэн төсвөөс авах авлага юм. Өөрөөр хэлбэл ТС нь ЗГ-ын мөнгөн хөрөнгийн нэг хэсэг, түүний эх үүсвэртэй холбоотой бүртгэлийг хөтөлж ирсэн байна. ТС-ийн баланс дахь Улсын нэгдсэн төсвөөс авах авлагын 48,087.3 сая төгрөг нь ЗГ-ын балансад нэгдэхдээ ЗГСНТ-ийн пассив талд төсвийн ерөнхийлөн захирагч нарт өгөх өглөгөөр тусдаг.

Сангийн сайдын 2004 оны 276 дугаар тушаалаар Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн нэгдсэн системд шилжиж буйтай холбогдуулан "Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай" хуулийн 9.1.7, 35.1 дэх заалтын дагуу Төв төрийн сан, аймаг, нийслэл, дүүргүүдийн Төрийн санд байршиж буй улсын төсвийн байгууллагуудын 2004 оны жилийн эцсийн харилцах дансны үлдэгдэл 26,122.1 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Ингэснээр ТС-ийн газрын Улсын нэгдсэн төсвөөс авах авлага уг дүнгээр буурч 21,965.2 сая/48,087.3 сая - 26,122.1 сая/ төгрөг болж фрибалансын тайланд -21,965.2 дүнтэйгээр харагдаж байна. 2005 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн ЗГСУМС-ийн Фрибаланс программд шилжих үеийн эхний үлдэгдэл дараахь байдалтай байна.

/Хүснэгт 8/**/сая төгрөгөөр/**

№	Үзүүлэлтүүд	Дүн
1	НДСан, агентлаг, орон нутгийн төсөв захирагч нарын харилцахын үлдэгдэл	60,934.9
2	ХҮДСургууль, Хүмүүнлэгийн их сургуулийн харилцахын үлдэгдэл	648.1
3	ТС-н хүүгийн орлогын харилцахын үлдэгдэл	2,240.4
4	Улсын төсвөөс авах авлага	-21,965.2
5	Мөнгөн хөрөнгийн дүн /1+2+3+4/	41,858.3
6	Үүнээс: Монголбанк дахь харилцахын үлдэгдэл	41,658.3
7	Хадгаламж банк дахь кассын үлдэгдэл	200.0

2004-2006 оны жилийн эцсийн Монголбанк, арилжааны банкууд дээр байршуулсан нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт 9/**/сая төгрөгөөр/**

Он	ТС-ийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл. Үүнээс:				Нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдэл
	Монголбанк дахь төгрөгийн харилцах данс	Монголбанк дахь валютын харилцах /төгрөгөөр/	Монголбанк дахь валютын хадгаламж /төгрөгөөр/	Арилжааны банкуудад байршуулсан хадгаламж	
2004	41,658.3	7,169.1	0.00	0.00	48,827.4
2005	48,113.2	17,445.1	0.00	53,996.5	119,554.8
2006	68,128.23	69,359.0	87,375.0	53,600.0	278,462.2

2004 оны жилийн эцсийн байдлаар ТС нь зөвхөн Монголбанк дээр төгрөгийн болон валютын харилцах дансны үлдэгдэлтэй байсан байна. Улсын эдийн засгийн өсөлтийн үр дүнд 2005, 2006 онуудад мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдсэнээр ТС мөнгөн хөрөнгийг Монголбанк дахь төгрөгийн харилцах дансанд байршуулж төлбөр тооцоогоо гүйцэтгэхээс гадна төсвийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор Монголбанк болон арилжааны банкуудад өндөр хүүтэй төгрөгийн болон валютын хадгаламж байршуулж ирсэн байна. Өөрөөр хэлбэл Засгийн газрын мөнгөн хөрөнгийг үр ашигтай удирдах зорилгоор сул эх үүсвэрийг ашиглаж улсын төсөвт 5.6 тэрбум төгрөгийн хүүгийн болон ханшийн зөрүүгийн ашиг оруулжээ. /Хүснэгт 1/

2004-2006 оны жилийн эцсийн ТС-ийн нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, төсвийн ерөнхийлөн захирагчдын баланс дахь харилцахын үлдэгдлийг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт 10/**/сая төгрөгөөр/**

Он	ТС-ийн нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	Үүнээс:	
		Төсвийн захирагч нарын харилцахын үлдэгдэл	Зөрүү
2004	48,827.4	89,945.7	-41,118.3
2005	119,554.8	62,074.3	57,480.5
2006	278,462.2	78,939.9	199,522.3

2004 онд мөнгөн хөрөнгийн зөрүү /-41,118.3/ хасах байгаа нь улсын төсвийн орлогын бүрдүүлэлт муу, тухайн оны төсвийн алдагдлыг нөхөхөд ТСНД-аас ашигласантай холбоотой байна. /Хүснэгт 4/

2006 оны жилийн эцсийн байдлаар нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг төсвийн захирагч нарын харилцах дансны үлдэгдэлтэй харьцуулахад 199,522.3 сая төгрөгөөр илүү байна. Энэ нь улсын төсвийн орлогын бүрдүүлэлт сайжирсантай холбоотой байна.

2005, 2006 оны жилийн эцсийн нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдэл илүүдэлтэй боловч ТС-ийн Монголбанк дахь төгрөгийн харилцах дансны үлдэгдэл, ТС дахь төсвийн захирагч нарын харилцах дансны үлдэгдэлээс дутуу харагдаж байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

<i>/Хүснэгт 11/</i>			<i>/сая төгрөгөөр/</i>
Он	ТС-ийн Монголбанк дахь төгрөгийн харилцахын үлдэгдэл	Төсвийн захирагч нарын харилцахын үлдэгдэл	Зөрүү
2004	41,658.3	89,945.7	-48,287.4
2005	48,113.2	62,074.3	-13,961.1
2006	68,128.23	78,939.9	-10,811.7

Төсвийн захирагч нарын харилцах дансны үлдэгдэл ТС дээр зөвхөн төгрөгөөр байршдаг ба ТС-ийн Монголбанк дахь төгрөгийн харилцах дансны үлдэгдэл, ТС дээрх төсвийн захирагч нарын харилцах дансны үлдэгдлийг шууд харьцуулан үнэлэлт өгөх боломжгүй юм. Учир нь мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг валютын харилцах, хадгаламж болон төгрөгийн хадгаламж хэлбэрээр байршуулдагтай холбоотой байна. Тухайлбал 2006 онд валютын хадгаламж 75,0 сая ам.доллар буюу 87,375.0 сая төгрөгөөр өссөн байна.

ТС нь Монголбанк дахь төгрөгийн харилцах дансны үлдэгдлийг ТС дээрх төсвийн захирагч нарын харилцах дансны үлдэгдэлтэй тохируулах зорилгоор 2007 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөр Монголбанк дахь хадгаламжаас валют арилжиж ТС-ийн төгрөгийн харилцах дансанд байршуулсан. Ингэснээр 2007 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар мөнгөн хөрөнгийн үлдэгдэл дараахь байдалтай гарчээ.

<i>/Хүснэгт 12/</i>			<i>/сая төгрөгөөр/</i>
Огноо	Монголбанк дахь төрийн сангийн төгрөгийн харилцах дансны үлдэгдэл	Төрийн сан дахь Төсвийн захирагч нарын харилцах дансны үлдэгдэл	
2007.06.30	183,621.3	183,621.3	0.00

Үүний дүнд ЗГСНТ дээрх ТС-ийн төсөвт байгууллагуудад төлөх өглөгийн дүн 0,00 болсон байна.

ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараахь **дүгнэлт** хийж байна. Үүнд:

1. Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдэхийн хэрээр үүнд зохицуулалт хийж төсвийн орлогыг нэмэгдүүлэх боломж ихэсч байна. Цаашид Төрийн сангийн мөнгөн хөрөнгийг зохицуулах журам, заавар, түүнд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.
2. Төсвийн ерөнхийлөн захирагчдын харилцахын үлдэгдэл 2006 оны жилийн эцсийн байдлаар Монголбанк дахь төгрөгийн харилцах данснаас 10,8 төгрөгөөр илүү тайлагнагдсан байна. Энэ нь ТСНД буюу төсвийн эрх захирагчдын мөнгөн хөрөнгөөс 10,8 тэрбум төгрөгийг Монголбанк болон арилжааны банкуудад валютын харилцах, хадгаламж, төгрөгийн хадгаламж хэлбэрээр байршуулсантай холбоотой байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Сангийн сайд Н.Баяртсайханд **зөвлөж** байна.

1. Тайлант хугацааны эцэст Монголбанк дахь төгрөгийн харилцах данс, ТС дахь төсвийн захирагч нарын харилцах дансны үлдэгдлийг эерэг дүнтэй буюу зөрүүгүй байлгах,
2. ТС-ийн газрын мөрдөж буй "Арилжааны банкуудад овернайт зээл олгох журам", "Төрийн сангийн хадгаламж байршуулах, хадгаламжийн сертификатыг худалдан авах тухай түр журам" болон холбогдох бусад журам заавруудыг шинэчилж, шийдвэр гаргах үе шатыг тодорхойлж, хариуцлагын тогтолцоог сайжруулах,
3. ТС-ийн газарт мөрдөж буй дээрх журмуудын дагуу Дотоод хяналтын тогтолцоог бий болгох.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: 26-02-47, <http://www.mof.gov.mn>

2007.11.02 № 5-79/5019
танай _____-ны № 1/365 -т

Санал хүргүүлэх тухай

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн зохицуулалт, түүний үр ашиг болон Төрийн санд байршиж буй төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2006 оны харилцах дансны үлдэгдэл Монголбанк дахь төгрөгийн харилцах дансны үлдэгдэл зөрүүтэй эсэхэд дүгнэлт гаргасан аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Дээрх асуудлуудтай холбоотой гарсан санал дүгнэлт болон зөвлөмжтэй бидний зүгээс санал нэг байна. Зөвлөмжийн 2 дахь хэсэгт дурьдсан Төрийн сангийн газарт мөрдөгдөж буй "Арилжааны банкуудад овернайт зээл олгох журам", "Төрийн сангийн хадгаламж байршуулах, хадгаламжийн сертификатыг худалдан авах тухай түр журам"-ыг Засгийн газрын мөнгөн хөрөнгийг байршуулахдаа илүү хяналттай, хариуцлагын тогтолцоог бий болгож, тус тусдаа байсан түр журмыг нэгтгэн боловсруулж Сангийн сайдын тушаалаар батлуулсан. Мөн аудитын явцад гаргасан зөвлөмжийн хүрээнд 7 дугаар сарын 1-нээс эхлэн санхүүгийн тайлант хугацааны эцэст Төрийн санд байршиж буй төсвийн ерөнхийлөн захирагч нарын харилцах дансны үлдэгдэлтэй Монголбанк дахь төгрөгийн харилцах дансны үлдэгдэл тэнцүү байхаар мөнгөн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Цаашдаа ч бид аудитын дүгнэлтээр өгсөн санал, зөвлөмжийг анхааралдаа авч үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах болно.



ТӨРИЙН САНГИЙН
ГАЗРЫН ДАРГА

Х.ПҮРЭВСҮРЭН



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2007 оны 11 сарын 06 өдөр

Дугаар 84

Улаанбаатар хот


Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23.2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг.Төрийн сангийн газрын мөнгөн хөрөнгийн зохицуулалтад хийсэн аудитын тайланг баталсугай.

Хоёр.Аудитын тайланг Сангийн сайд Н.Баяртсайханд хүргүүлсүгэй.

Гурав.Аудитын тайлангийн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч түүний үр дүнг 2007 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт танилцуулахыг Сангийн сайд Н.Баяртсайханд зөвлөсүгэй.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Л.ЖАВЗМАА

